

НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 5 САРЫН ТАЙЛАН

Нийтийн номын сан 2023 оны 05 сарын 15 аас Хүүхдийн уншлагын танхимд номын тооллого явагдаж байна.



ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯРЫГ ТОХИОЛДУУЛАН Аймгийн Нийтийн номын сангаас Монгол үндэсний бичиг соёл, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, судлах, монгол бичгээ сурч эзэмших, хойч үедээ өвлүүлэх, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх сурталчлах зорилгоор “МОНГОЛ БИЧГИЙН “АВАРГА УНШИГЧ” уралдааныг уламжлал ёсоор зохион байгуулав. Уралдааныг ахмад багш С. Оюунцэцэг, "Жаахан шарга" ХЖТ-ын дуучин А. Идэрзаяа, арга зүйч Т. Чандмань нар шүүн явуулав. Энэ удаагийн уралдаанд Баруун-Урт сумын ЕБ-ын 1-4 сургууль, МСҮТ-ийн сурагчдаас гадна Түвшинширээ сумын ЕБС-ийн сурагчид ирж оролцон, өргөн хүрээтэй явагдлаа.

6-7-р ангийн ангилалд 64 сурагч,

ЕБС-ийн 8-12, МСҮТ-ийн ангилалд 58 сурагч

Насанд хүргэсдийн ангилалд 16 хүн нийт 138 хүн оролцож дүнгээ гаргалаа.

ЕБС-ийн 6-7-р ангийн ангилалд:

Тэргүүн байр: ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 7д ангийн сурагч Баттүшиг / 103 үг /

Дэд байр: ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 7д ангийн сурагч Мэнд-Амар/ 91 үг/

Гутгаар байр: ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 7д ангийн сурагч Нарантөгөлдөр / 90 үг/

ЕБС-ийн 8-12, МСҮТ-ийн ангилалд:

Тэргүүн байр: ЕБ-ын 1 дүгээр сургууль.11а ангийн сурагч Т. Анужин / 94 үг /

Дэд байр: ЕБ-ын 3 дугаар сургуулийн 9а ангийн сурагч З. Намуун / 86 үг/

Гутгаар байр: ЕБ-ын 3 дугаар сургуулийн 9а ангийн сурагч Э. Бэрцэцэг / 81 үг/

Насанд хүрэгсдийн ангилалд:

Тэргүүн байр: Баруун-Урт сумын XI цэцэрлэгийн багш С. Өнөржаргал / 157 үг/

Дэд байр: ЕБ-ын 1 дүгээр сургуулийн англи хэлний багш Б. Энхзул / 145 үг /

Гутгаар байр: Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар. Аудитор Б. Ариунзул /131 үг/ тус тус уншиж, шилдгээр шалгарлаа.

Оролцсон бүх оролцогчиддоо баярлалаа.

Шагналыг "Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2023" арга хэмжээн дээр гардуулна.



Аймгийн Нийтийн номын сангаас Хөрөнгө оруулалт хөгжлийн чуулганы арга хэмжээнд Сүхбаатар нутгийн зохиолч, яруу найрагчдын уран бүтээлээр номын үзэсгэлэнг 120 ном, номын худалдааг 50 гаруй номоор гарган сурталчилж байна.



Үндэсний бичиг соёл номын өдрүүдийг 2023 оны 05 дугаар сарын 27, 28 ны өдрүүдэд зохион байгуулахаар боллоо.



Байгууллагын ойр орчимын хог хаягдалаа мөн модоо услан цэвэрлэлээ.



Статистак мэдээ:

Байнгын уншигч-2112, ирэгсэд-3074, ном олголт 3080